МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/11 Улаанбаатар хот

Техникийн шаардлага батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хил тогтоох, байнгын шав тэмдэг тавих техникийн шаардлага”-ыг 1 дүгээр, тайлангийн нүүр болон тайланд хавсаргах маягтууд /“..... дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан ажлын тайлан”, “Шав тэмдгийн жагсаалт”, “Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицлыг газар дээр байгуулсан акт”/-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү техникийн шаардлагыг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Салбарын хяналтын газар /Б.Мөнхдөл/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

САЙД Ж.ГАНБААТАР

1508 01 0034

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ХИЛ ТОГТООХ, БАЙНГЫН ШАВ ТЭМДЭГ ТАВИХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгүүлснээс хойш 3 сарын дотор геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбицолуудыг тогтоолгож, байнгын шав тэмдэг суулгуулна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавихдаа дараах техникийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицолын WGS систем, UTM тусгагт хийнэ.

2. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр хийсэн хэмжилтийн үр дүнгээр тогтоож, байнгын шав тэмдэг суулгаж баталгаажуулна.

3. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийн нарийвчлал нь 1:1000-ны масштабтай газрын зургийн нарийвчлалтай буюу байрлалын хувьд 10 см, өндрийн хувьд 20 см-ийн нарийвчлалтай байна.

4. Шав тэмдгийг 1.5 м урттай 50 мм-ээс багагүй хөндлөн огтлолтой төмөр материалаар хийж, газар дээр байрлах цэгийн толгой хэсэгт чагтан тэмдэглэгээ хийсэн байна.

5. Шав тэмдгийг бэлтгэх, газарт суулгах, гаднах тэмдэглээс хийх болон шав тэмдгийн хувийн хэрэг хийхдээ Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19-ийг дагаж мөрдөнө.

6. Шав тэмдгийн дээд хэсэгт тусгай зөвшөөрөл, булангийн цэгийн дугаарыг ган хасууураар арилгахгүйгээр тод бичнэ.

7. Шав тэмдгийн солбицол, байршлын бүдүүвч болон фото зургийг тайланд хавсаргана. Шав тэмдгийн жагсаалтыг маягт 2-ын дагуу үйлдэнэ.

8. Шав тэмдгийг газарт бэхэлж, маягт 3-ын дагуу акт үйлдэнэ.

9. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг суулгаж, баталгаажуулсан хэмжилтийн үр дүнгийн үнэн зөв, бодит байдлыг хэмжилт хийсэн тухайн байгууллага, албан тушаалтан бүрэн хариуцна.

10. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан тайланг 3 хувь үйлдэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамаар хянуулах ба хянуулсан 1 хувийг Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст хүргүүлэн уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгүүлж, тусгай зөвшөөрлийн хувийн хэрэгт хадгалуулна.

-----oOo-----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

..... ДУГААРТАЙ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ХИЛИЙГ ТОГТООЖ, БАЙНГЫН ШАВ ТЭМДЭГ ТАВЬСАН АЖЛЫН ТАЙЛАН

Байршил:.....

Планшетийн дугаар: .....

Захиалагч: “.....” ХХК
Албан тушаал /...../
(Нэр, гарын үсэг, тэмдэг)

Гүйцэтгэгч: “.....” ХХК
Албан тушаал /...../
(Нэр, гарын үсэг, тэмдэг)

Хянасан: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
.....дарга / ...../
/нэгжийн даргын албан тушаалыг бичнэ/
(Нэр, гарын үсэг, тэмдэг)

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
.....улсын /ахлах/ байцаагч / ...../
/тухайн чиглэлийн албан тушаалыг бичнэ/
(Нэр, гарын үсэг, тэмдэг)

20 .... он

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А111 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Маягт 2

ШАВ ТЭМДГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Шав тэмдэгийн дугаар	Тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол				Газар дээр хийсэн хэмжилтийн солбицол	
		газар зүйн солбицол		тэгш өнцөгтийн солбицол			
		B	L	X	Y	X	Y

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Маягт 3



АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ХИЛИЙН БУЛАНГИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛЫГ ГАЗАР ДЭЭР БАЙГУУЛСАН АКТ

20 .. оны ...сарын ...өдөр .....

/аймаг, хот, сум, дүүрэг, тосгон/

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр: .....
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: .....
3. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан аж ахуйн нэгжийн нэр: .....
4. Хэмжилт хийсэн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: .....
5. Хэмжилт хийхэд ашигласан геодезийн тулгуур цэгийн нэр, дугаар: .....
6. Хэмжилт хийсэн багажны мэдээлэл: .....
7. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн булангийн цэг, шав тэмдэгийн тоо: .....

ХҮЛЭЭН АВСАН:

..... /Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч/-ийг төлөөлж:

.....	.....	.....
/Албан тушаал/	/Гарын үсэг, тэмдэг/	/овог, нэр/

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

..... /Хэмжилт хийсэн компани/-ийг төлөөлж:

.....	.....	.....
/Албан тушаал/	/Гарын үсэг, тэмдэг/	/овог, нэр/